



"ЦЭЦЭ ЛАНД" ХХК-Д

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
**ХОТ БАЙГУУЛАЛТ,
ХОТЫН СТАНДАРТЫН ГАЗАР**

Наадамчдын зам 1200, Арцатын ам,
23 дугаар хороо, Хан-Уул дүүрэг,
Улаанбаатар хот, 17100
Утас: (976) 7270 7700
Цахим хуудас: www.uda.ub.gov.mn

2024.05.08 № 01-11/24
танай _____-ны № _____-т

**Сонсох ажиллагааны мэдэгдэл
хүргүүлэх тухай**

Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд (хуучнаар)-ын 2021 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийн А/288 дугаар тушаалаар Хан-Уул дүүргийн 8 дугаар хороо, Богд Хан-Уулын Дархан цаазат газрын тусгай хамгаалалттай газар нутгийн Дарга толгойн ам, 17102 бүсчлэлд байрлах 1781111071 нэгж талбарын дугаар бүхий 5.3925 га газрын 2021 оны 0211866 дугаартай гэрчилгээг үндэслэн танай компани 2022 оны Архитектур төлөвлөлтийн даалгавар, Загвар зураг батлуулсан байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2023 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн "Газар ашиглах эрх хүчингүй болгох тухай" А/634 дүгээр тушаалаар Хан-Уул дүүргийн 8 дугаар хорооны нутаг дэвсгэр дэх 1781111071 нэгж талбарын дугаар бүхий газар ашиглах эрхийг хүчингүй болгосон тул Захиргааны ерөнхий хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1 дэх хэсэг, 49.3.1 дэх заалтыг үндэслэн 2022 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн МЗХ2022/18-016 дугаартай Архитектур төлөвлөлтийн даалгавар, 2022 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн Загвар зургийг хүчингүй болгохоор энэ хуулийн 27 дугаар зүйлийн 27.4.2 дахь заалтад заасан хэлбэрээр сонсох ажиллагаа явуулж байна.

Иймд Захиргааны ерөнхий хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсэгт заасны дагуу захиргааны шийдвэр гаргахад ач холбогдол бүхий нөхцөл байдлын талаар тайлбар, санал гаргах боломжтой тул холбогдох тайлбар, бусад баримтыг 2024 оны 05 дүгээр сарын 24-ни өдрийн дотор ирүүлнэ үү. Мэдээлэл авах утас: Хуулийн хэлтэс 72707700.

ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

